



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2019 оны 02 сарын 02 өдөр

Дугаар А/79

Арвайхээр

Салбар комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1, Сангийн сайдын “Бүртгэл хөтлөлтийн улсын үзлэг зохион байгуулах тухай” 2018 оны 302 дугаар тушаалыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бүртгэл хөтлөлтийн улсын үзлэгийг зохион байгуулах салбар комиссыг дараахь бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга: И.Доржсүрэн – Засаг даргын орлогч

Гишүүд: Д. Нэмэхбаяр – Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга

Н. Эрдэнэсүвд - Аймгийн Засаг даргын дэргэдэх Татварын хэлтсийн дарга

А. Мөнхтөр – Аймгийн Засаг даргын дэргэдэх Улсын бүртгэлийн газрын дарга

Б. Баяржаргал – Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн ерөнхий нягтлан бодогч

Ц. Пүрэвсүрэн - Арвайхээр сумын Санхүү албаны дарга

Нарийн бичгийн дарга: Ч.Болормаа – Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн бүртгэлийн мэргэжилтэн

2. Салбар комиссын ажиллах журмыг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

3. Бүртгэл хөтлөлтийн улсын үзлэг зохион байгуулах ажилд мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлж, хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Нэмэхбаяр)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100138

Аймгийн Засаг даргын 2019... оны ...
дугаар сарын ...-ны өдрийн ... дугаар
захирамжийн хавсралт

НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН УЛСЫН ҮЗЛЭГ ЗОХИОН БАЙГУУЛАХ САЛБАР КОМИССЫН АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Өвөрхангай аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй нэгж байгууллага болон төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн тухай, Аудитийн тухай хуулийн хэрэгжилт, олон улсын стандартын нэвтрэлтийн түвшинг тодорхойлох, анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, ашиглагдаж байгаа санхүүгийн программ хангамж, санхүүгийн болон татварын тайлан бэлтгэсэн байдалд үзлэг хийхэд энэхүү журмыг мөрдлөг болгоно.

Хоёр. Зорилго, хамрах хүрээ, хугацаа

2.1 Нягтлан бодох бүртгэлийн тухай, Аудитийн тухай хуулийн хэрэгжилт, олон улсын стандартын нэвтрэлтийн түвшинг тодорхойлох, анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, санхүүгийн программ хангамжийн ашиглалт, нсгтлан бодогч, эд хариуцагч нарын боловсрол, ажил эрхлэлтийн байдлыг судлаж улсын хэмжээний мэдээлэлийн нэгдсэн баазыг бий болгох, цаашид хэрэгжүүлэх бодлогыг тодорхойлоход энэхүү үзлэгийн зорилго оршино.

2.2 Бүртгэл хөтлөлтийн улсын үзлэгийг үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй нэгж байгууллагууд болон төсвийн байгууллагуудад 2019 оны 1 дүгээр сарын 01 нээс 5 дугаар сарын 20-ны өдөр хүртэл хугацаанд явуулна.

2.3. Улсын үзлэгт 2018 оны 12 дугаар сарын 31 ний өдрийн байдлаар улсын бүртгэлд бүртгэлтэй өмчийн бүх төрлийн аж ахуй нэгж, байгууллага болон төсвийн байгууллагад хамаарна.

Гурав. Үзлэгийн хүрээнд хийгдэх ажлууд.

3.1 Аж ахуй нэгж байгууллага болон төсвийн байгууллагын мэдээлэлийн баазыг улсын бүртгэлийн ерөнхий газар, Татварын ерөнхий газар болон холбогдох бусад төрийн байгууллагуудтай хамтран тулган баталгаажуулна.

3.2 Улсын үзлэгийн санал асуулгыг 2019 оны 01 сарын 01 нээс 03 сарын 01 ны хооронд санхүүгийн тайлангийн И-баланс систем болон төсвийн байгууллагын Э-Тайлан системээр батлагдсан асуулгын маягтын дагуу хүлээн авна.

3.3 Төв комиссын нэгтгэсэн үзлэгийн урьдчилсан дүнг үндэслэн хуваарийн дагуу түүврийн аргаар аж ахуй нэгж байгууллагуудын ажлын байранд очиж асуулгын маягттай тулган холбогдох баримттай тулган баримтын шалгалт хийнэ.

3.4 Салбар комисс нь аж ахуй нэгж, байгууллагуудын анхан шатны болон нягтлан бодох бүртгэл хөтлөлтийн байдал, нөлөөлж буй хүчин зүйлд үнэлэлт, дүгнэлт өгч тайланг бэлтгэн 2019 оны 5 дугаар сарын 01-ний өдрийн дотор Төв комисст хүргүүлнэ.